



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/73/СТА-ТШЗ

Баянхонгор хот, 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424      Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345      Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

## Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт               |
| АОУС     | Аудитын олон улсын стандарт                                 |

## АГУУЛГА

|       |  |       |
|-------|--|-------|
| 1     | Аудитын гэрчилгээ .....  | 3-4   |
| 2     | Аудитын тайлан.....  | 5     |
| 2.1   | Оршил.....   | 5     |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 5     |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                       | 5     |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....  | 6     |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 7     |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....   | 8     |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....  | 8     |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....  | 8     |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....                                   | 9     |
| 2.9   | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                 | 9     |
| 2.10  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....  | 9     |
| 2.11  | Шилэн дансны мэдээлэл .....  | 9     |
| 2.12  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....  | 9     |
| 2.13  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....   | 10    |
| 3     | Менежментийн захидал.....  | 11    |
| 3.1   | (Аудитын чиглэл).....  |       |
| 4     | Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 12-18 |
| 4.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....   | 12    |
| 4.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....  | 13-14 |
| 4.3   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....  | 15-16 |
| 4.4   | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....   | 16    |
| 4.5   | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....   | 17-18 |

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.01.30 № 2/03

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

2518468

Аудитаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### ОРШИЛ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ХХҮГ-ын дарга Д.Амарсанаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.21-нээс 2019.01.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.18-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийг ажилтай, орлоготой болгох замаар ядуурлыг бууруулж амьжиргааны түвшинг сайжруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийг ажилтай, орлоготой болгох
- Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд болон зорилтод бүлгийн иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:ы

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол Улсын Засгийн газрын 2016.12.21-ний өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018.08.07-ний өдрийн 207 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу төсвийн байгууллагад бүртгэлтэй барилга байгууламж, газрыг дахин үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах ажил тайлант онд хийгдсэн байна.

### **Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 47 оноо авсан тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 3 програм хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт дунд гэж үзлээ.

### **Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### **Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 652784,4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 13,053.65 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### **Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### **2.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитаар мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 420012 төгрөгөөр илүү, мөн дүнгээр АО-чоос төлөх НДШ-ийн зардлыг дутуу илэрхийсэн. Мөн ХХОАТ-т 89291 төгрөг, ҮЭ-ийн татварт 12470 төгрөг илүү шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулав.

#### **Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй.

#### **Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой улсын төсвөөс 2018 онд анх 571650,0 мянган төгрөг баталж, оны дундуур 6, 9, 12 саруудад өөрчлөлт орж, сүүлийн тодотгосон төсвөөр 585030,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 583176,6 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа бөгөөд тогтмол зардлыг үндэслэл муутай төлөвлөж, бүлэг дотор гүйлгэн зарцуулсан байна.

#### **Өөрийн орлогын төлөвлөгөө байхгүй.**

#### **Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Мөнх-Эрдэнэ гүйцэтгэж, аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### **Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Аудитын илрүүлэлт: Тогтмол зардлын төлөвлөлт үндэслэлгүйгээс бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Аудитын зөвлөмж: Тогтмол зардлын төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл               | Эцсийн үлдэгдэл              |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b><u>6,133,300.00</u></b>   | <b><u>7,467,761.00</u></b>   |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | 45,600.00                    | 101,761.00                   |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 45,600.00                    | 101,761.00                   |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 6,087,700.00                 | 7,366,000.00                 |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | 6,087,700.00                 | 7,366,000.00                 |
| 35410       | Бичиг хэргийн материал  | 1,029,500.00                 | 1,725,000.00                 |
| 35420       | Аж ахуйн материал   | 5,058,200.00                 | 5,641,000.00                 |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>181,918,701.21</u></b> | <b><u>215,406,423.51</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 181,918,701.21               | 215,406,423.51               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | 181,244,951.21               | 197,463,673.51               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц  | 181,272,000.00               | 145,772,177.00               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл   | -84,341,833.53               | 00.00                        |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл  | 16,000,000.00                | 00.00                        |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл   | -11,555,555.48               | 00.00                        |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 164,080,741.07               | 102,556,803.07               |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | -109,182,021.42              | -71,564,310.57               |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 42,726,160.00                | 42,726,160.00                |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | -17,754,539.43               | -22,027,155.99               |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | 673,750.00                   | 17,942,750.00                |
| 39301       | Програм хангамж   | 1,155,000.00                 | 1,155,000.00                 |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | -481,250.00                  | -712,250.00                  |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 00.00                        | 17,500,000.00                |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>188,052,001.21</u></b> | <b><u>222,874,184.51</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b><u>9,000.00</u></b>       | <b><u>00.00</u></b>          |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 9,000.00                     | 00.00                        |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | 9,000.00                     | 00.00                        |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>  | 9,000.00                     | 00.00                        |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг  | 9,000.00                     | 00.00                        |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>188,043,001.21</u></b> | <b><u>222,874,184.51</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 188,043,001.21               | 222,874,184.51               |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,436,981,459.57             | 1,454,481,459.57             |
| 51101       | Өмч: - төрийн   | 1,436,981,459.57             | 1,454,481,459.57             |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | -1,248,938,458.36            | -1,275,587,839.63            |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | -1,248,938,458.36            | -1,248,938,458.36            |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | 00.00                        | -26,649,381.27               |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 00.00                        | 43,980,564.57                |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>188,052,001.21</u></b> | <b><u>222,874,184.51</u></b> |

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл     | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>729,390,966.00</b>   | <b>626,033,306.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>14,484,585.00</b>    | <b>7,882,646.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 14,484,585.00           | 7,882,646.00          |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 14,484,585.00           | 7,882,646.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 14,484,585.00           | 7,882,646.00          |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>714,906,381.00</b>   | <b>618,150,660.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 548,702,800.00          | 585,030,000.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 548,702,800.00          | 585,030,000.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 166,203,581.00          | 20,730,000.00         |
| 131102      | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 129,807,081.00          | 00.00                 |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө      | 20,496,500.00           | 19,520,000.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                    | 00.00                   | 1,210,000.00          |
| 131106      | Төсвийн урамшуулал  | 15,900,000.00           | 00.00                 |
| <b>1340</b> | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>   | 00.00                   | 12,390,660.00         |
| 134001      | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих  | 00.00                   | 12,390,660.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>2,150,831,264.91</b> | <b>650,016,020.51</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>2,150,831,264.91</b> | <b>650,016,020.51</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 2,026,669,476.91        | 630,786,029.51        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 441,097,988.00          | 454,259,476.00        |
| 210101      | Үндсэн цалин  | 441,097,988.00          | 454,259,476.00        |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 49,229,694.67           | 55,408,395.00         |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 49,229,694.67           | 36,966,908.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 00.00                   | 4,619,800.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 00.00                   | 3,725,830.50          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 00.00                   | 917,894.50            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 00.00                   | 9,177,962.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | 46,112,234.00           | 52,773,557.00         |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 3,473,303.00            | 9,417,885.00          |
| 210302      | Түлш, халаалт   | 41,573,532.00           | 41,564,616.00         |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 1,065,399.00            | 1,791,056.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 62,579,655.00           | 11,726,460.00         |
| 210401      | Бичиг хэрэг   | 11,903,375.00           | 4,349,900.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 12,061,038.00           | 4,198,138.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 5,980,166.00            | 2,064,062.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 18,000.00               | 1,114,360.00          |
| 210407      | Аж ахуйн материал худалдан авах зардал  | 32,617,076.00           | 00.00                 |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 00.00                   | 1,394,800.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 00.00                   | 150,000.00            |
| 210604      | Урсгал засвар   | 00.00                   | 1,244,800.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | 12,631,000.00           | 1,153,000.00          |
| 210702      | Дотоод албан томилолт   | 12,631,000.00           | 1,153,000.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | 1,573,916.00            | 20,861,520.00         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 00.00                   | 18,804,940.00         |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 500,000.00              | 800,000.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 613,500.00              | 300,000.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | 125,600.00              | 147,400.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо   | 66,000.00               | 39,600.00             |

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |   |                          |                       |
|-------------|---|--------------------------|-----------------------|
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                     | 249,000.00               | 602,700.00            |
| 210807      | Газрын төлбөр                                       | 19,816.00                | 166,880.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>              | <b>1,413,444,989.24</b>  | <b>33,208,821.51</b>  |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 645,000.00               | 00.00                 |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                  | 1,412,799,989.24         | 33,208,821.51         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                             | <b>124,161,788.00</b>    | <b>19,229,991.00</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                       | <b>114,323,480.00</b>    | <b>17,376,660.00</b>  |
| 213202      | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                | 00.00                    | 12,390,660.00         |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00                    | 4,986,000.00          |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | 114,323,480.00           | 00.00                 |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>9,838,308.00</b>      | <b>1,853,331.00</b>   |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                               | 9,838,308.00             | 1,853,331.00          |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>           | <b>-1,421,440,298.91</b> | <b>-23,982,714.51</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>              | <b>6,590,312.00</b>      | <b>2,666,666.76</b>   |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                      | 00.00                    | 2,666,666.76          |
| 225005      | Үнэ төлбөргүй гарсан зардал                         | 6,590,312.00             | 00.00                 |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>     | <b>-6,590,312.00</b>     | <b>-2,666,666.76</b>  |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                      | <b>-1,428,030,610.91</b> | <b>-26,649,381.27</b> |

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>   |                       |                       |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>   | <b>714,906,381.00</b> | <b>618,150,660.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>714,906,381.00</b> | <b>618,150,660.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 548,702,800.00        | 585,030,000.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 548,702,800.00        | 585,030,000.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 166,203,581.00        | 20,730,000.00         |
| 131102      | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 129,807,081.00        | 00.00                 |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө      | 20,496,500.00         | 19,520,000.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                    | 00.00                 | 1,210,000.00          |
| 131106      | Төсвийн урамшуулал  | 15,900,000.00         | 00.00                 |
| <b>1340</b> | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>   | 00.00                 | 12,390,660.00         |
| 134001      | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих  | 00.00                 | 12,390,660.00         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>  | <b>714,906,381.00</b> | <b>618,150,660.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>714,906,381.00</b> | <b>618,150,660.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>665,814,073.00</b> | <b>598,920,669.00</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 441,097,988.00        | 454,361,237.00        |
| 210101      | Үндсэн цалин  | 352,218,988.00        | 454,361,237.00        |
| 210102      | Нэмэгдэл  | 70,525,400.00         | 00.00                 |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 18,353,600.00         | 00.00                 |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 47,157,846.00         | 55,362,795.00         |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 47,157,846.00         | 37,057,213.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 00.00                 | 3,663,713.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 00.00                 | 4,579,641.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 00.00                 | 915,929.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 00.00                 | 9,146,299.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | 40,963,649.00         | 52,782,557.00         |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 3,473,303.00          | 9,417,885.00          |
| 210302      | Түлш, халаалт   | 36,424,947.00         | 41,573,616.00         |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 1,065,399.00          | 1,791,056.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 57,043,174.00         | 10,093,200.00         |
| 210401      | Бичиг хэрэг   | 5,119,800.00          | 3,016,940.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 45,119,858.00         | 4,198,138.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 5,810,166.00          | 2,064,062.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 993,350.00            | 814,060.00            |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 212,000.00            | 213,000.00            |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 212,000.00            | 213,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 3,667,850.00          | 2,168,300.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 1,287,700.00          | 707,200.00            |
| 210604      | Урсгал засвар   | 2,380,150.00          | 1,461,100.00          |
| <b>2107</b> | <b>Томиллолт, зочны зардал</b>  | 12,912,000.00         | 1,153,000.00          |
| 210702      | Дотоод албан томиллолт  | 12,912,000.00         | 1,153,000.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | 42,868,676.00         | 22,786,580.00         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 41,049,760.00         | 20,730,000.00         |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 500,000.00            | 800,000.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 613,500.00            | 300,000.00            |

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |   |                      |                      |
|-------------|---|----------------------|----------------------|
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                          | 125,600.00           | 147,400.00           |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                       | 66,000.00            | 39,600.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                     | 494,000.00           | 602,700.00           |
| 210807      | Газрын төлбөр                                       | 19,816.00            | 166,880.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>              | 19,890,890.00        | 00.00                |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 19,890,890.00        | 00.00                |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                             | <b>49,092,308.00</b> | <b>19,229,991.00</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                       | 39,254,000.00        | 17,376,660.00        |
| 213202      | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                | 00.00                | 12,390,660.00        |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал            | 23,354,000.00        | 00.00                |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00                | 4,986,000.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | 15,900,000.00        | 00.00                |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | 9,838,308.00         | 1,853,331.00         |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                               | 9,838,308.00         | 1,853,331.00         |

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн        | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|--------------------------|---|
| C01 | <b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 1,436,981,459.57                | 00.00                 | 179,092,152.55           | 1,616,073,612.12                        |
| C03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>1,436,981,459.57</b>         | <b>00.00</b>          | <b>179,092,152.55</b>    | 1,616,073,612.12                        |
| C07 | Тайлант үеийн үр дүн                             | 00.00                           | 00.00                 | -1,428,030,610.91        | -1,428,030,610.91                       |
| C08 | <b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>1,436,981,459.57</b>         | <b>00.00</b>          | <b>-1,248,938,458.36</b> | 188,043,001.21                          |
| D01 | <b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>1,436,981,459.57</b>         | <b>00.00</b>          | <b>-1,248,938,458.36</b> | 188,043,001.21                          |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>1,436,981,459.57</b>         | <b>00.00</b>          | <b>-1,248,938,458.36</b> | 188,043,001.21                          |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00                           | 43,980,564.57         | 00.00                    | 43,980,564.57                           |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | 17,500,000.00                   | 00.00                 | -26,649,381.27           | -9,149,381.27                           |
| D09 | <b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>1,454,481,459.57</b>         | <b>43,980,564.57</b>  | <b>-1,275,587,839.63</b> | 222,874,184.51                          |

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Өмнөх оны             |                | Тайлант оны           |                |
|-----------------------|---|-----------------------|----------------|-----------------------|----------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                |                       |                |                       |                |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                        | 564,602,800.00        | 563,703,165.00 | 585,030,000.00        | 583,176,669.00 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | 564,602,800.00        | 563,703,165.00 | 585,030,000.00        | 583,176,669.00 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | 548,702,800.00        | 547,803,165.00 | 580,044,000.00        | 578,190,669.00 |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | 441,506,100.00        | 441,097,988.00 | 454,797,000.00        | 454,781,289.00 |
| 210101                | Үндсэн цалин  | 352,627,100.00        | 352,218,988.00 | 365,032,600.00        | 00.00          |
| 210102                | Нэмэгдэл  | 70,525,400.00         | 70,525,400.00  | 70,525,400.00         | 00.00          |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт   | 18,353,600.00         | 18,353,600.00  | 19,239,000.00         | 00.00          |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | 47,175,600.00         | 47,157,846.00  | 55,095,600.00         | 54,942,743.00  |
| 210201                | Тэтгэврийн даатгал  | 29,515,400.00         | 00.00          | 37,063,700.00         | 36,637,161.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал  | 4,415,000.00          | 00.00          | 4,508,000.00          | 3,663,713.00   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал   | 3,532,100.00          | 00.00          | 3,606,400.00          | 4,579,641.00   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал  | 883,000.00            | 00.00          | 901,600.00            | 915,929.00     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал   | 8,830,100.00          | 00.00          | 9,015,900.00          | 9,146,299.00   |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | 41,375,400.00         | 40,963,649.00  | 53,769,700.00         | 52,782,557.00  |
| 210301                | Гэрэл, цахилгаан  | 4,387,300.00          | 3,473,303.00   | 5,281,600.00          | 9,417,885.00   |
| 210302                | Түлш, халаалт   | 32,396,800.00         | 36,424,947.00  | 39,196,800.00         | 41,573,616.00  |
| 210303                | Цэвэр, бохир ус   | 4,591,300.00          | 1,065,399.00   | 9,291,300.00          | 1,791,056.00   |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | 10,093,200.00         | 10,092,916.00  | 10,093,200.00         | 10,093,200.00  |
| 210401                | Бичиг хэрэг   | 3,361,000.00          | 3,115,300.00   | 3,361,000.00          | 3,016,940.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун  | 2,689,800.00          | 3,490,650.00   | 2,689,800.00          | 4,198,138.00   |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 2,975,900.00          | 2,493,616.00   | 2,975,900.00          | 2,064,062.00   |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                     | 1,066,500.00          | 993,350.00     | 1,066,500.00          | 814,060.00     |
| 2105                  | <b>Нормативт зардал</b>   | 213,800.00            | 212,000.00     | 213,800.00            | 213,000.00     |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                     | 213,800.00            | 212,000.00     | 213,800.00            | 213,000.00     |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | 3,669,600.00          | 3,667,850.00   | 2,169,600.00          | 2,168,300.00   |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл   | 2,177,100.00          | 1,287,700.00   | 677,100.00            | 707,200.00     |
| 210604                | Урсгал засвар   | 1,492,500.00          | 2,380,150.00   | 1,492,500.00          | 1,461,100.00   |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | 2,563,100.00          | 2,522,000.00   | 1,563,100.00          | 1,153,000.00   |
| 210702                | Дотоод албан томилолт   | 2,563,100.00          | 2,522,000.00   | 1,563,100.00          | 1,153,000.00   |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 1,836,000.00          | 1,818,916.00   | 2,342,000.00          | 2,056,580.00   |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                        | 500,000.00            | 500,000.00     | 800,000.00            | 800,000.00     |
| 210803                | Даатгалын үйлчилгээ   | 615,000.00            | 613,500.00     | 495,000.00            | 300,000.00     |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар                                      | 128,700.00            | 125,600.00     | 228,700.00            | 147,400.00     |
| 210805                | Тээврийн хэрэгслийн   | 72,600.00             | 66,000.00      | 39,600.00             | 39,600.00      |

**Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

|             |   |                |                |                |                |
|-------------|---|----------------|----------------|----------------|----------------|
|             | оношлогоо   |                |                |                |                |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                     | 499,700.00     | 494,000.00     | 602,700.00     | 602,700.00     |
| 210807      | Газрын төлбөр                                       | 20,000.00      | 19,816.00      | 176,000.00     | 166,800.00     |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>              | 270000.00      | 270000.00      | 0.00           | 0.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 270,000.00     | 270,000.00     | 00.00          | 00.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                             | 15900000.00    | 15900000.00    | 4986000.00     | 4986000.00     |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00          | 00.00          | 4,986,000.00   | 4,986,000.00   |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | 15,900,000.00  | 15,900,000.00  | 00.00          | 00.00          |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>               | 564,602,800.00 | 563,703,165.00 | 585,030,000.00 | 585,030,000.00 |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                      | 564,602,800.00 | 547,803,165.00 | 585,030,000.00 | 585,030,000.00 |
| 131001      | Улсын төсвөөс санхүүжих                             | 564,602,800.00 | 547,803,165.00 | 585,030,000.00 | 00.00          |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                             | 53.00          | 53.00          | 53.00          | 53.00          |
| 620001      | Удирдах ажилтан                                     | 01.00          | 01.00          | 01.00          | 01.00          |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                                   | 44.00          | 44.00          | 44.00          | 44.00          |
| 620003      | Үйлчлэх ажилтан                                     | 08.00          | 08.00          | 08.00          | 08.00          |
| 650001      | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                  | 45.00          | 45.00          | 45.00          | 45.00          |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)          | 08.00          | 08.00          | 08.00          | 08.00          |